

# ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Гэрээний №  он  сар  өдөр

## 1. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

Эцэг /Эх/-ийн нэр\*: Өөрийн нэр\*: Регистр №\*: 

### ОРШИН СУУГАА ХАЯГ

Хот/Аймаг\*:  Дүүрэг/Сум\*: Хороо/Баг\*:  Гудамж\*: Нууц дугаар\*:  Тоот\*: 

### АЖИЛ ЭРХЛЭЛТ/сонгоно уу/

 Малчин  Хувийн компанийн ажилтан Төрийн албан хаагч  Оюутан/сурагч Хувиараа бизнес эрхлэгч  Ажилгүй

### ХОЛБОО БАРИХ

Гар утас 1\*: Гар утас 2: Э-шуудан: 

### ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

Овог нэр:  Утасны дугаар:  Таны юу болох: 

\* Тэмдэглэгээтэй хэсгийг заавал бөглөнө үү. Дээрх мэдээллүүдийг бүрэн зөв бөглөснөөр ДДЭШ ТВ компаниас санал болгож буй байнгын болон цаг үеийн шинж чанартай бүтээгдэхүүн үйлчилгээний урамшууллын мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой болох юм.

## 2. ХҮЛЭЭЛЦСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Бараа материалын нэрс	Тоо хэмжээ	Тэмдэглэл
1	Удирдлага /зай/	1 ш	
	12W залгуур	1 ш	
	HDMI залгуур	1 ш	
	220W залгуур	1 ш	
	Гарын авлага	1 ш	
2	Смарт карт	1 ш	
3	Дуран буюу ЛНБ	1 ш	
4	Бороо, цасны хамгаалалт	1 ш	
5	Кабель утас	10 метр	
6	Төмөр толгой	2 ш	
7	Төмөр таваг	1 ш	
	Дурангийн тахир төмөр	1 ш	
	Татуур богино төмөр	2 ш	
	Суурь төмөр	1 ш	
	Градус төмөр	1 ш	
	Даруулга жижиг төмөр	2 ш	
	Гурвалжин суурь	1 ш	
	ЛНБ тогтоогч /боолтын хамт/	1 уут	

### Ашиглах төхөөрөмжийн бүртгэл, мэдээлэл

Смарт картын дугаар:  Settop box мак хаяг: 

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭТЭЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН :

“ДДЭШ ТВ” ХХК-ийг төлөөлж:

Албан тушаал: .....

Ажилтны нэр: .....

Гарын үсэг: .....

ХЭРЭГЛЭГЧ :

Хэрэглэгчийн нэр: .....

Гарын үсэг: .....

.....

# ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Нэг талаас хиймэл дагуулын телевизийн үйлчилгээ үзүүлэгч "ДДэш ТВ" ХХК /цаашид "ДДэш" гэх/, Нөгөө талаас энэхүү гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж хүлээн зөвшөөрсөн иргэн /цаашид "Хэрэглэгч" гэх, дангаар нь "Тал" хамтад нь "Талууд" гэх/ нар дор дурдсан нөхцлийг харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. ДДэш нь телевизийн олон сүвгийн нэвтрүүлгийг /цаашид "Үйлчилгээ" гэх/ хэрэглэгчид үзүүлэх, хэрэглэгч нь гэрээнд заасны дагуу төлбөр төлөх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.3. Энэхүү гэрээнд заасан нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
  - 1.3.1 **Хэрэглэгч** - ДДэштэй үйлчилгээний гэрээ байгуулж, үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэг хүлээсэн, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн болон харъяалалгүй хувь хүнийг;
  - 1.3.2 **Үйлчилгээг хаах** - Үйлчилгээнийхээ хугацааг сунгуулаагүй хэрэглэгчийн үйлчилгээг ДДэш-ийн зүгээс түр зогсоохыг;
  - 1.3.3 **Дэлгэрэнгүй хууль** - Хэрэглэгчийн ашигласан үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан баримтыг;
  - 1.3.4 **Нууц дугаар** - Хэрэглэгч нь ДДэшТВ үйлчилгээний дансаасаа төлбөр төлөх тохиолдолд ашиглах, хэрэглэгчийн өөрийн сонгосон 4 оронтой тоог;
  - 1.3.5 **Сарын суурь хураамж** - Хэрэглэгчийн сонгосон үйлчилгээний төрлөөс хамаарч сар бүр урьдчилан төлөх төлбөрийг;
  - 1.3.6 **Нэмэлт үйлчилгээ** - Түрээсийн кино сангийн үйлчилгээ болон төлбөрт сүвгийг;
  - 1.3.7 **Үндсэн сүвгийн багц** - Дагалдах суваг бүхий үндсэн багцын үйлчилгээг;
  - 1.3.8 **Спорт сүвгийн багц** - Үндсэн багцаас гадна нэмэлтээр авч болох спорт сүвгуудын багцыг;
  - 1.3.9 **Кино сан** - Хэрэглэгч төлбөр төлж кино түрээслэн үзэх боломж бүхий сүвгуудыг;
  - 1.3.10 **Багц төхөөрөмж** - Компаниас үйлчилгээнд гаргаж байгаа тавган антенн, хүлээн авагч болон бусад дагалдах хэрэгсэл, төхөөрөмжүүдийг;
  - 1.3.11 **Дагалдах хэрэгсэл** - Багцын төхөөрөмжүүдээс дангаар нь борлуулахыг;
  - 1.3.12 **Антенн** - Хиймэл дагуулаас ирж байгаа дохиог 1 цэгт төвлөрүүлж ЛНБ руу дамжуулах төхөөрөмжийг;
  - 1.3.13 **Дуран буюу ЛНБ** - Тавган антеннаас ирсэн дохиог шуугиангүйгээр өсгөж хүлээн авагч руу кабель утсаар дамжуулах төхөөрөмжийг;
  - 1.3.14 **Коксиал кабель утас** - Дурангаас өгсөн дохиог унтралт багатайгаар хүлээн авагч руу дамжуулах холбох хэрэгслийг;
  - 1.3.15 **Set top box** - Хүлээн авагч төхөөрөмжийг;
  - 1.3.16 **Смарт карт** - Хиймэл дагуулаас нууцлалтайгаар ирж байгаа дохио буюу мэдээллийг хэрэглэгчийн хүлээн авагч дээр задлан хүргэж байгаа хэрэгслийг;
  - 1.3.17 **Картын дугаар** - Хэрэглэгчийн сүвгийн нууцлалыг цахимжуулсан хэлбэрийг;

## ХОЁР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 2.1 Хэрэглэгч нь ДДэшийн хүлээн авагч, смарт карттай байх бөгөөд энэхүү гэрээний нөхцөлд үүдийг хүлээн зөвшөөрснөөр үйлчилгээг авах боломжтой болно.
- 2.2 ДДэш нь үндсэн болон нэмэлт багцуудын үйлчилгээг хэрэглэгчид санал болгох бөгөөд хэрэглэгч нь үндсэн үйлчилгээг идэвхжүүлснээр нэмэлт үйлчилгээг идэвхжүүлэх эрхтэй болно.
- 2.3 Хэрэглэгч нь гэрээ байгуулах болон смарт картыг шинээр авах тохиолдолд хүчин төгөлдөр иргэний үнэмлэх /гадаад паспорт, жоононы үнэмлэх/-тэйгээ өөрийн биеэр ирж үйлчлүүлэх бөгөөд энэхүү гэрээнд тусгах мэдээллийг ДДэш-д үнэн зөв өгөх.
- 2.4 ДДэшийн үйлчилгээг авах зорилгоор тодорхой төлбөр төлж эзэмшиж буй смарт карт нь хэрэглэгчийн өмч байх бөгөөд хэрэглэгч уг картыг үрэгдүүлсэн, гэмтээсэн, бусдад шилжүүлснээс болж үүссэн харилцааг хэрэглэгч нь өөрөө хариуцна.
- 2.5 Гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж хэрэглэгч нь үйлчилгээгээ ашиглах эрхтэй болох бөгөөд уг гэрээг талууд харилцан тохиролцон цуцлагдах өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 2.6 Хэрэглэгч банкаар үйлчилгээний төлбөрөө төлсөн бол банк хоорондын гүйлгээнээс хамааран үйлчилгээний эрх нээгдэх хугацаа удааширч болно.
- 2.7 ДДэш нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг өөрийн мэдээллийн суваг /вэй сайт, facebook хуудас/-ийг ашиглан олон нийтэд мэдээллийг 5 хоногийн өмнө хүргэснээс гэрээнд өөрчлөлт орсонд тооцно.

## ГУРАВ.ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 3.1 Хэрэглэгч нь үйлчилгээг өөрийн хүсэлтээр сонгох, сонгосон үйлчилгээнийхээ талаар холбогдох мэдээллийг авах;
- 3.2 Хэрэглэгч нь өөрийн сонирхолын дагуу нэмэлт үйлчилгээ авах;
- 3.3 Хэрэглэгч үйлчилгээний талаарх санал, хүсэлт, гомдлоо ДДэшийн албан ёсны хаяг, утсаар хандаж гаргах;
- 3.4 Хэрэглэгч өөрийн хувийн мэдээллийг үнэн зөв өгөх;
- 3.5 Хэрэглэгч гэрээнд тусгагдсан байгаа мэдээлэл нь өөрчлөгдөх, хаягийн шилжилт хийсэн тохиолдолд ажлын 5 хоногт багтаан ДДэшд мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй улмаас үүсэх аливаа хариуцлагыг ДДэш хүлээхгүй.
- 3.6 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг бүрэн төлснөөр үйлчилгээг авах;
- 3.7 Хэрэглэгч нь үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд, хуулийн хүрээнд ашиглах;
- 3.8 Хэрэглэгч нууц дугаараа гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй бөгөөд дамжуулснаас үүсэх аливаа хохиролыг хэрэглэгч өөрөө хариуцна;
- 3.9 Хэрэглэгч нь үйлчилгээг ДДэшээс батлан гаргасан үйлчилгээний нөхцөлийн дагуу ашиглах;
- 3.10 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрөө төлөхдөө гүйлгээний утга дээр смарт картын дугаар, регистрийн дугаар, үйлчилгээ идэвхжүүлэх сар, холбоо барих утасны дугаарыг заавал бичнэ.
- 3.11 Хэрэглэгч нь ДДэшээс үзүүлж буй үйлчилгээний /үндсэн сүвгийн багц, спорт сүвгийн багц, кино сангийн үйлчилгээ, төлбөртэй нэмэлт сүвгүүд гэх зэрэг/-ний талаар хангалттай мэдээлэлтэй байх ба хэрэв бүтээгдэхүүн үйлчилгээний талаар эргэлзээ байвал энэ тухайгаа лавлаж, хангалттай мэдээлэл авсан байх үүрэгтэй.
- 3.12 Хэрэглэгчийн санаатай болон санамсаргүй үйлдлээс болж ашиглах заавар зөрчигдөж, орчин тойрны өмч хөрөнгөд шууд болон шууд бусаар учирсан хохирлыг компани хариуцахгүй.

## ДӨРӨВ. ДДЭШИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1 Хэрэглэгчээс гэрээнд заасан үүрэгээ биелүүлэхийг шаардах;
- 4.2 Техник технологийн шинэчлэл хийж, засвар хийх бол боломжит мэдээллийн хэрэгслийн аль нэгийг ашиглан Хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр үйлчилгээг түр хаах;
- 4.3 Хэрэглэгчид шинээр үйлчилгээ санал болгох, урамшуулал, хөнгөлөлтийн талаар мэдээлэл өгөх, холбоо барих зорилгоор Хэрэглэгчийн хувийн мэдээлэлд дурьдсан хаяг, утас, и-мэйлээр хандаж;
- 4.4 Үйлчилгээг өөрийн техникийн боломж, хүчин чадлын хүрээнд, стандартын дагуу чанартай үзүүлэх;
- 4.5 Хэрэглэгчийн мэдээлэл болон дэлгэрэнгүй хуулгыг энэхүү үйлчилгээний гэрээ байгуулсан хэрэглэгчид, болон эрх бүхий байгууллагын шаардлагаар гаргаж өгөхөөс бусад тохиолдолд задруулахгүй байх;
- 4.6 Хэрэглэгчээс үйлчилгээний талаар ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч, гаргасан гомдлыг түргэн шуурхай барагдуулах;
- 4.7 ДДэш нь Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх;
- 4.8 ДДэш нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээг дангаар цуцлах;
- 4.9 Хэрэглэгчид үйлчилгээний эрх дуусч байгаа тухай сануулах;

## ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО ТҮҮНИЙГ ТӨЛӨХ АРГАЧЛАЛ

- 5.1 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлөх бөгөөд төлсөн төлбөрт зохих хугацаа дуусахаас өмнө нэмж төлбөр төлөөгүй тохиолдолд үйлчилгээний эрх хаагдах болно.
- 5.2 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг ДДэшийн салбар, Юнител ХХК-ийн салбарууд болон

- 5.3 мобайл диллерт бэлнээр эсвэл Хаан банк: 505 905 0128, Голомт банк: 110 298 7935, Төрийн банк: 106 600 004668, Хас банк: 500 023 2657, Худалдаа хөгжлийн банк: 499 135 803 тоот дансанд банкаар болон интернет банкаар төлнө.
- 5.4 Төлбөртэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Талууд асуудлыг бүрэн шийдвэрлэсний дараа илүү төлөлт гарсан тохиолдолд илүү төлбөрийг смартын данс руу шилжүүлэх бөгөөд утас бол хэрэглэгч нэмж төлнө.
- 5.5 Сарын үйлчилгээний төлбөрт МҮОНТ-ийн сарын хураамж хамаарахгүй бөгөөд бусад татвар, хураамж орсон болно.
- 5.6 Банкны үйлчилгээг ашиглан төлбөр хийхдээ зааврын дагуу утгыг зөв бөглөх үүрэгтэй ба, Бүрэн бөглөснөөс үүдсэн асуудлыг ДДэш хариуцахгүй. Тоног төхөөрөмжийн үнэ болон үйлчилгээний хураамжид НВАТ орсон болно.

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА, ТҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ҮНДЭСЛЭЛ

- 6.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээх, гэрээ цуцлах үндэслэл болно.
- 6.2 Хэрэглэгч энэхүү гэрээний 3-р зүйлд заасан үүргээ биелүүлээгүйгээс болж үүсэх аливаа хариуцлагыг ДДэш хариуцахгүй.
- 6.3 Үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор техникийн өргөтгөл, шинэчлэлтээс хамаарч сүлжээ доголдож болох ба энэ тохиолдолд ДДэшийн зүгээс нийтэд мэдэгднэ.
- 6.4 Хэрэглэгчийн смарт карт ашиглалттай холбоотой аливаа үйлдлийг ДДэш хариуцахгүй.
- 6.5 Монгол Улсын хууль тогтоомжинд заасан гэнэтийн болон давагдахгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үйлчилгээ тасалдсан тохиолдолд ДДэш хариуцлага хүлээхгүй.

## ДОЛОО. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

- 7.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
- 7.2 Гэрээг 2 хувь үйлдэж, талууд хувь тус бүрийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.3 ДДэш нь дараах үндэслэлээр Хэрэглэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр үйлчилгээг зогсоох, гэрээ цуцлах эрхтэй болно. Үүнд:
  - 7.3.1 Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн;
  - 7.3.2 Хэрэглэгч төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй;
  - 7.3.3 Хэрэглэгч смарт картыг ДДэшд мэдэгдэлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлсэн;
  - 7.3.4 Хэрэглэгч эрх зүйн чадвар, чадамжгүй болсон нь тогтоогдсон;
- 7.4 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 7.5 ДДэш нь гэрээг онлайн хэлбэрт оруулж болох бөгөөд хэрэглэгч тухайн нөхцлийг зөвшөөрсөнд тооцогдоно.

## ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БАТАЛГАА

- Тоног төхөөрөмжийн баталгааны хуудас /цаашид "баталгааны хуудас" гэх/ нь зөвхөн ДДэшТВ ХХК /цаашид "компани" гэх/-иас худалдан авсан болон бусад хөнгөлөлт, урамшуулын нөхцлөөр авсан Хүлээн авагч /цаашид "тоног төхөөрөмж" гэх/-д хамаарах бөгөөд баталгаа хугацааны доторх үйлдвэрийн доголдолдыг засах, ижил төрлийн тоног төхөөрөмжөөр солих харилцаад үйлчилнэ.
- 1 Зөвхөн компаниас худалдан авсан болон хөнгөлөлт, урамшуулын нөхцлөөр авсан тоног төхөөрөмжийг худалдан авсан баримтыг гэрээний хувьтай хамт авчирсан тохиолдолд баталгааны нөхцөл үйлчилнэ. Эдгээр баримтууд байхгүй, бичилтийг өөрчилсөн, арилгасан, засварласан тохиолдолд баталгааны хуудас үйлчлэхгүй.
  - 1.1 Адагтар болон HDMI кабель, залгуур, удирдлага зэрэгт баталгаа байхгүй.
  - 1.2 Тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа нь Хүлээн авагч-г худалдан авсан болон хөнгөлөлт, урамшуулын нөхцлөөр компаниас авсан өдрөөс хойш 6 /зургаан/ сар байна.
  - 3 Баталгаа нь дараах тохиолдлуудад хамаарахгүй. Үүнд:
    - 4.1 Тоног төхөөрөмжийг зориулалтын бусаар ашигласан;
    - 4.2 Бусад засварын газраар засвар хийлгэсэн, схем, дизайныг өөрчилсөн, лацгыг хөдөлгөсөн, унагаасан;
    - 4.3 Гадна болон дотор эд ангийн бүх төрлийн механик гэмтэл;
    - 4.4 Дотор нь гадны биет, бодис, ус, шингэн, шавьж орсноос үүдсэн гэмтэл;
    - 4.5 Байгалийн гамшиг, түймэр, санамсаргүй гадаад хүчин зүйлүүдийн (аянга, цахилгааны хэлбэлзэл гэхэмт) нөлөөллөөс үүдэн гарсан гэмтэл;
    - 4.6 Стандартад тохироогүй 220В-оос дээш, доош тэжээл, холбоо хэрэгсэл, кабель, хэрэглэснээс үүдэн гарсан гэмтэл;
  - 5 Гэмтэлтэй тоног төхөөрөмжийг зөвхөн ДДэшТВ ХХК-ний үйлчилгээний салбар болон засварын төвд худалдан авсан болон хөнгөлөлт, урамшуулын нөхцлөөр авсан баримт үзэсвэл үйлчилгээний гэрээ/-г үндэслэн хүлээж авна.
  - 6 Худалдан авсан болон хөнгөлөлт, урамшуулын нөхцлөөр авсанбаримтыг хаяж үрэгдүүлсэн бол баталгаа хүчингүй болох ба дахин нөхөж олгохгүй.
  - 7 Тоног төхөөрөмжөө авчирч өгөхдөө тоос шороо, хүнсний үлдэгдэл, тос зэргийг сайтар цэвэрлэсэн байх.
  - 8 Гэмтэлтэй тоног төхөөрөмжийг үйлчилгээний салбар, засварын төвд хүргэх зэрэг аливаа зардлыг хэрэглэгч өөрөө хариуцна.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХЭЭ СУНГАХТАЙ ХОЛБОТОЙ ЗӨВЛӨМЖ:

Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө ДДэшТВ үйлчилгээний салбар, Юнителийн үйлчилгээний салбар, Юнителийн мобайл диллер болон банкны салбаруудад хандан төлөх боломжтой.

### Банкны салбарт хандан төлбөрөө тушаах бол:

- Смарт картын дугаарыг бүгдийг бичих
- Сунгалт хийх гэж буй багцын нэр болон төлбөрийн дүнг зөв бичих
- Гар утасны дугаараа бичих

### Мобайл банк болон интернэт банкаар тушаах бол:

- Сүвгийн багцаа сунгах бол
- Смарт картын сүүлийн 9 оронг бичих
  - Сунгалт хийх гэж буй багцын нэр болон төлбөрийн дүнг зөв бичих
  - Сунгалтын мөнгөн дүнг зөв сонгох
  - Сунгалт хийх хугацааг зөв бичих

### Кино түрээслэн үзэхээр Смарт картаа цэнэглэх бол:

- Смарт картын дугаараа бичээд данс гэж бичнэ.

### Банкны дансны дугаар

- |   |                          |   |                            |
|---|--------------------------|---|----------------------------|
|  | ХААН банк 505 905 0128   |  | Төрийн банк 1066 0000 4668 |
|  | Голомт банк 110 298 7935 |  | Хас банк 500 023 2657      |
|  | ХХБанк 499 135 803       |  | Капитал банк 2120002848    |

Санамж: Бичилтээ зөв бичиж өгсний дараа таны үйлчилгээний эрх 15-20 минутын дараа нээгдэнэ.